



БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 12 сарын 17 өдөр

Дугаар VIII/02

Дархан баг

Г 7
Сумын Засаг даргын үйл ажиллагааны
“Хөгжлийг түүчээлье” хөтөлбөрийн
2025 оны хэрэгжилтийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэгхангай сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Хөгжлийг түүчээлье” хөтөлбөрт тусгагдсан 2025 оны жилийн эцсийн байдлаар 85,6 хувьтай буюу үр дүнтэй гэж дүгнэсүгэй.

2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс гаргасан санал шүүмжлэлд дурдагдсан асуудал, зарим салбаруудын ажлын явцыг эрчимжүүлж, “Хөгжлийг түүчээлье” хөтөлбөрийн 2025 оны зорилтот түвшнийг бүрэн хангах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга (Э.Эрдэнэбулган)-д даалгасугай.

3. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн II/03 дугаар тогтоолоор баталсан боловч уг хөтөлбөр нь Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу дүгнэхэд хүндрэлтэй байгаа тул Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үнэлэх шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Мөнхтулга)-т даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (И.Ичинхорлоо)-д даалгасугай.

ДАРГА

Н.ЭРХЭМБАЯР

